



175

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/85

Шивээговь сум

Тамхи худалдан борлуулах тусгай
зөвшөөрлийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.9, Зөвшөөрлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 11 дүгээр зүйлийн 11.6, Улсын тэмдэгтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 86 дугаар тогтоол “Сумын нутаг дэвсгэрт тамхины тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1.Сумын 2 дугаар баг, 22 дугаар зөрлөгийн нутаг дэвсгэрт байрлах “Ган зам” хүнсний дэлгүүрт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 27-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаатай сунгасугай.

2.Тусгай зөвшөөрлийн хураамж болох 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Амартүвшин)-д үүрэг болгосугай.

3.Тамхи худалдан борлуулах үйл ажиллагааг Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, 6.7.8, 6.7.10, 6.7.12, 6.7.14 заалтын дагуу мөрдөж ажиллахыг (Ган зам хүнсний дэлгүүр)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажиллахыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн дэд хурандаа (Б.Шинэбаяр), Хүнс жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Амартүвшин) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА